



УВС АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



УВС АЙМГИЙН ХҮН АМЫН АМЬДАРЧ БУЙ ОРЧИН НӨХЦӨЛ



Улаангом 2018

Агуулга


I.	Газар зүйн байрлал	2
II.	Уур амьсгал	3
III.	Ус, Ургамал	3
IV.	Амьтны аймаг	3
V.	Засаг захиргаа	3-4
VI.	Эдийн засаг	4
VII.	Орон сууцны нөхцөл	5
VIII.	Аймгийн аюулгүй байдал	6

I. Увс аймгийн газар зүйн байрлал

Увс аймаг нь Монгол орны баруун хойморт Их нууруудын хотгорын хойд хэсэгт өргөрөгийн дагуу сунаж тогтсон 69.6 мян.км² газар нутагтай. Байгалийн мужлалтаар Увс, Хяргас нуурын хотгорын цөлжүү хээр, хуурай хээрийн дэд муж, Ханхөхийн нурууны дундаж өндөр бэлэрхэг уул бүхий хээр, хуурай хээр, ар хажуугийн ойн дэд муж, Монгол Алтайн зүүн хэсгийн /Хархираа, Түргэн/ цулдам уул, хотгор ян сарьдаг, уулын нуга, уулын хээрийн дэд мужид тус тус багтана. Нийслэл Улаанбаатараас 1400 орчим км алслагдсан. Аймгийн төв Улаангом сум д.т.д 939 метр өндөрт оршдог. Увс, Хяргас нуур түүний эргэн тойрны говийн бүс, Хархираа, Түргэн, Ханхөхийн өндөр уулс бүхий говь, цөлөөс өндөр уулын мөнх цас, мөсөн гол хүртэлх төв Азийн гадагш урсгалгүй ай савын босоо бүслүүрийн бүхий л хэв шинжийг тусгасан ландшафт газарзүйн өвөрмөц тогтоцтой. Нутаг дэвсгэрийн 8.2 %-ийг уулын ойт хээр, 14.5 %-ийг өндөр уулын, 37.7 %-ийг хээрийн, 39.6 %-ийг говь цөлийн бүс эзэлдэг. Хамгийн нам цэг нь далайн түвшнээс дээш 758.9 метрт буй Увс нуурын түвшин, хамгийн өндөр цэг нь далайн түвшнээс дээш 4250 метрт өргөгдсөн Цагаан Дэглий оргил юм. Хархираа, Түргэний салбар уулс далайн түвшнээс дээш 4000 метрээс дээш өндөртэй 31 цаст оргилуудтай гэдгээрээ Увс нутаг ялангуяа уулчдын анхаарал, сонирхлыг ихэд татна.

Увс аймаг нутгийн зүүн хэсэгт газар тариалан хөгжүүлсэн, баруун хэсэгтээ уул уурхайн үйлдвэрлэл явагдах бөгөөд аймгийн төвдөө барилгын, хүнсний үйлдвэрүүдтэй. Увс аймаг нь хил хязгаарын хувьд баруун талаараа 200 км Баян-Өлгий, өмнө талаараа 152 км Ховд аймаг, зүүн талаараа 340 км Завхан аймаг, хойд талаараа 575 км ОХУ-тай тус тус хиллэдэг. ОХУ руу гарах 2 хилийн боомт (Давст сумын нутагт Боршоогийн боомт, Тэс сумын нутагт Тэсийн боомт) үйл ажиллагаа явуулдаг.

Зураг 1. Хилийн урт, км



I. Уур амьсгал

Увс аймгийн цаг уурын байдал нь Их нууруудын хотгор, Алтайн салбар уулсын бүсэд орших тул эрс тэс эх газрын уур амьсгалтай. Увс нуурын хотгор нь эргэн тойрон уулсаар хүрээлэгдсэн уулс хоорондын хотгор төдийгүй төв Азийн антициклоны төв юм. Иймд өвлийн улиралд агаарын даралт 1-р сард 1054 гПа болж, агаарын температур Малчин, Тэс, Улаангом, Баруунтуруун, Давст, Зүүнговь, Зүүнхангай, Сагил, Түргэн, Хяргас сумдад 1-12 өдөр хөрсөндөө -40 хэмээс дээш хүйтэрсэн нь монгол оронд тэмдэглэгдсэн хамгийн бага утга тул Увс нуурын хотгорыг Монгол орны хамгийн хүйтэн газар гэж үздэг. Зуны улиралд хамгийн дулаандаа 7 - р сард хөрсний гадаргын дундаж температур Баруунтуруун, Зүүнхангай, Малчин, Өмнөговь, Өндөрхангай, Цагаанхайрхан, Тэс, Түргэн, Улаангом сумдад нэмэх 30 хүртэл дулаарч бусад сумдад нэмэх 30 –аас илүү дулаарсан бөгөөд цаг агаарын дундаж температур 2017 онд -2.4 с-ийн хэмтэй байсан байна.

II. Ус, Ургамал

Аймгийн нутагт говь-хээрийн бүс зонхилсон өвс ургамал нөмрөгийн хувьд тачирдуухан боловч төрөл зүйл олон, жимс жимсгэний ургамалтай. Хар мод, хус, хуш, нарс, улиас, бургас, улаан харгана, алтан харгана нутгийн ихэнхи хэсгээр тархсан. Зүүнговь, Сагил, Түргэн сумын нутгаар мөнх ногоон гацуур модтой. Увс нуурын эрэг орчим, Тэсийн голын адаг орчмоор улиасан төгөл, бургасан шугуй, тэмээн харгана бүхий алаг өвст, үент, нугын бүлгэмдэл зонхилно. Алтангагнуур, вансэмбэрүү, алтан хундага, нохойн хошуу, тарваган шийр, халгай, таван салаа, хунчир зэрэг эмийн ургамалтай. Чацаргана, үхрийн нүд,

гүзээлзгэнэ, тошлой, мойл, аньс, зэдгэнэ зэрэг жимс жимсгэнэ ургадаг. Увс аймагт 2017 оны байдлаар ойн нөөц бүхий 20961.6 мян.м3 талбай байна. Ойтой талбай 236.6 мянган га, ой доторхи ойгүй талбай нь 4.4 мянган га-г эзлэж байна.

Аймгийн хэмжээнд гадаргын усны нөөц 3443.9 м3, газар доорхи усны нөөц 168.0 сая м3 байна. Усны 779 эх үүсвэр хамгаалтанд байдаг байна.

III. Амьтны аймаг

Тус аймаг 64 зүйлийн хөхтөн, 270 зүйлийн шувуу, 7 зүйлийн загас, 411 зүйлийн ургамалтай. Хан Хөхий, Хархираа, Түргэний уулсаар буга, гахай, аргаль, янгир, ирвэс, шилүүс, хадны суусар, нохой зээх, хээр тал зарим голын хөндий уулархаг нутгаар чоно, үнэг, дорго, тарвага зэрэг зэрлэг ан амьтан амьдардаг. Нууруудад хун, нугас, хотон зэрэг усны шувууд, уул талаар хойлог, тоодог, тас, бүргэд, ёл, Ховд, Бөхмөрөний голд алтан гургалдай зэрэг төрөл бүрийн жигүүртэн шувуудтай. Тэс, Нарийний голын сав нь хүйтэн цуст амьтад амьдардаггүй бүсэд хамаарна. Бөөрөг дэлийн элсний районд хээрийн бүлгэмдэл тархсан. Хонин гүрвэл, говийн гүрвэл, могой гүрвэл, бамбай хоншоорт могой зэрэг мөлхөгчидтэй. Ан агнуурын амьтдаас хярс, мануул, өмхий хүрэн, солонго элбэг бол агнуурын шувуудаас ногтруу, дагуурын ятуу элбэг тархсан.

IV. Засаг захиргаа

Аймгийн төв нь Улаангом хот, засаг захиргааны нэгжийн хувьд 19 сум, 93 багт хуваагддаг. Аймгийн төвөөс хамгийн ойрхон сум Түргэн 28 км, хамгийн алслагдсан нь Зүүнхангай сум 365 км зайтай. Хамгийн их өрх, хүн амтай нь Тэс сум бөгөөд хамгийн их толгой мал буюу 285349 тоо толгой мал тоолуулсан бол хамгийн бага өрх, хүн амтай нь Давст сум ба 437 өрх айл, 1703 иргэнтэйгээр 2017 оны жилийн эцэст тоологдсон байна.


Зураг 2. Аймгийн өрх, хүн ам, малын тоо 2017 оны жилийн эцсийн байдлаар

№	сум	нийт өрх	хүн ам	малын тоо
1	Баруунтуруу	759	2700	68543
2	Бөхмөрөн	576	2284	134496
3	Давст	437	1703	83229
4	Завхан	500	1843	126456
5	Зүүнговь	709	2778	123834
6	Зүүнхангай	640	2305	163671
7	Малчин	655	2494	161823
8	Наранбулаг	1043	4266	240149
9	Өлгий	607	2417	131493
10	Өмнөговь	1143	4626	227931
11	Өндөрхангай	910	3232	215201
12	Сагил	635	2463	166887
13	Тариалан	971	4022	154027
14	Түргэн	607	2150	136743
15	Тэс	1301	5273	285349
16	Ховд	661	2456	157549
17	Хяргас	635	2585	194584
18	Цагаанхайрх	574	2061	171506
19	Улаангом	8433	30946	186413
20	Бүгд	21796	82604	3129884

V. Эдийн засаг

Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн чиглэлээр 104 аж ахуйн нэгж статистикийн мэдээнд хамрагдаж тайлант онд 13.6 тэрбум төгрөгийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэж 14.6 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн байна. Нийт үйлдвэрлэлийн 40.4 хувийг дулаан түгээлт усан хангамж, 39.4 хувийг боловсруулах салбарын үйлдвэрлэл, 20.2 хувийг уул уурхайн олборлолт эзлэж байна.

Зураг 3. Аж үйлдвэрийн салбарын бүтэц



2017 онд аж үйлдвэрийн салбарын ажилчдын тоо 839 байгаа нь өнгөрсөн оны үетэй харьцуулахад 4.6 хувиар өсч 1 ажилчины хөдөлмөрийн бүтээмж 1.2 (7.4 %) сая төгрөгөөр өссөн байна.

VI. Орон сууцны нөхцөл


2017 оны байдлаар Увс аймгийн нийт өрхийн 8527 буюу 39.0 хувь нь аймгийн төвд харин үлдсэн 61 хувь нь бусад 18 суманд оршин сууж байна. Нийт өрхийн тоог сууцны төрлөөр нь ангилбал бие даасан тохилог сууцанд 0.3 хувь, гэрт 83.0 хувь, нийтийн байранд 0.3 хувь, орон сууцны байшинд 5.1 хувь, сууцны тусдаа байшинд 11.2 хувь, бусад сууцанд 0.1 хувь оршин сууж амьдарч байна.

Зураг 4. Хүн амын орон сууцны нөхцөл *

Байршил	Бүгд	Бие даасан тохилог сууц	Гэр	Нийтийн байр	Орон сууцны байшин	Сууцны тусдаа байшин	Бусад сууц
Баруунтуруун сум	765	2	575	25		162	1
Бөхмөрөн сум	574		490			84	
Давст сум	439		400	9	2	27	1
Завхан сум	497		468			29	
Зүүнговь сум	706		651	1		54	
Зүүнхангай сум	647		538			109	
Малчин сум	655		586	1	1	67	
Наранбулаг сум	1 038		1 017	2		16	3
Өлгий сум	607		579		1	24	3
Өмнөговь сум	1 143		1 060			82	1
Өндөрхангай сум	905		775			130	
Сагил сум	634		578	4		51	1
Тариалан сум	958		854	2		101	1
Түргэн сум	606		577		1	28	
Тэс сум	1 290		1 263			27	
Улаангом сум	8 527	56	6 156	25	1 109	1 176	5
Ховд сум	660		624			36	
Хяргас сум	636		499		1	134	2
Цагаанхайрхан сум	579		471			108	
НИЙТ	21 866	58	18 161	69	1115	2 445	18

*2018 оны 2-р улирлын байдлаар


Зураг 5. Нийт өрхийн сууцны төрөл бүтцээр



VII. Аймгийн аюулгүй байдал


2017 онд бүртгэгдсэн гэмт хэргийн тоо 356 болж өнгөрсөн оны мөн үеэс 10.6 хувиар, өмнөх 4 жилийн дунджаас 9 гэмт хэргээр буюу 2.5 хувиар тус тус өссөн байна. Нийт гэмт хэргийн дийлэнх нь Улаангом суманд үйлдэгдсэн бөгөөд нийт 165 тохиолдол гарснаас бусдын бие мах бодид гэмтэл учруулах гэмт хэргийн 76, бусдын эд хөрөнгө хулгайлах 51 тохиолдол гарч өнгөрсөн оны мөн үеэс гэмт хэргийн гаралт 7.8 хувиар өссөн байна. Нийт гэмт хэргийн улмаас 8 хүн нас барж, 193 хүн гэмтэж, 375 иргэн хохирсон байна.

Зураг 6 Гэмт хэргийн гаралт, жил бүрийн эцэст, тоо




Гэмт хэргийг үйлдэгдсэн байдлаар нь авч үзвэл эмэгтэй хүн оролцсон 23, согтуугаар үйлдэгдсэн 114, гэр бүлийн хүчирхийллийн улмаас гарсан гэмт хэрэг 21, бүлэглэн 20, гудамж талбайд 50, гэр орон сууцанд 117 гэмт хэрэг гарсан байна.

Зураг 6. Гэмт хэргийн гаралт, төрлөөр, тоо



Гэмт хэргийн улмаас 487.9 сая төгрөгийн хохирол учраад байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 4.7 хувиар буурсан байна. Иргэд байгууллагад учруулсан нийт хохирлын 368.2 сая төгрөг буюу 75.5 хувийг нөхөн төлүүлжээ. Хэрэг бүртгэл, мөрдөн байцаалтын үед 337.2 сая төгрөгийн хөрөнгийг битүүмжилсэн байна.

Зураг 12.3 Хохирол, нөхөн төлөлт сая.төгрөг



Ашигласан материал

Аймгийн танилцуулга

Аймгийн нийгэм эдийн засгийн танилцуулга